



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/28

Мандалговь

Г Ажил хавсран гүйцэтгэх тухай. Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Их хурлын байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 3.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захиргаа, хуулийн тасгийн татварын улсын байцаагч Б.Жанчивдоржийг өөрийн санаачилгаар албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах, тайлагнах ажлыг эрхлэх эрх бүхий албан тушаалтны үүргээс 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2. Захиргаа, хуулийн тасгийн хуулийн зөвлөх И.Замэндийг албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах, тайлагнах ажлыг эрхлэх эрх бүхий албан тушаалтны ажилд 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

3. И.Замэндийд үндсэн цалингийн 20 хувийн нэмэгдэл олгохыг нягтлан бодогч (Н.Долгорсүрэн)-нд зөвшөөрсүгэй.

ДАРГА *М. Туяацэцэг* М.ТУЯАЦЭЦЭГ

